



**НИЙСЛЭЛИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын уралдаан  
тэмцээний зар сурталчилгаа,  
шторк хийлгэх зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн дунд 2024 оны гуравдугаар, дөрөвдүгээр саруудад зохион байгуулах Биеийн тамир, спортын уралдаан тэмцээний жагсаалтыг нэгдүгээр, зар сурталчилгаа, шторк хийлгэх төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зар сурталчилгаа, шторк хийлгэхэд шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, уралдаан тэмцээний зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Зар, сурталчилгаа, шторкыг мэргэжлийн өндөр түвшинд хийлгэхэд хяналт тавьж, нийслэлийн иргэдэд хүргэж ажиллахыг зохион байгуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын  
даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны  
өдрийн 111 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

Биеийн тамир, спортын уралдаан  
тэмцээний жагсаалт



№	Биеийн тамир, спортын уралдаан тэмцээний жагсаалт	Зохион байгуулах хугацаа
1.	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн шигшээ тэмцээн	III/19-22
2.	Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн шигшээ тэмцээн	IV/04

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын  
даргын 2024 оны 23 дугаар сарын 25-ны  
өдрийн 1111 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт



Биеийн тамир, спортын уралдаан  
тэмцээний зар сурталчилгаа, шторк  
хийлгэх төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.	Зар сурталчилгаа, шторк хийлгэх зардал	1	1,500,000	1,500,000
			ДҮН	1,500,000